

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Үндэсний Давхар Даатгал ХК -ийн хувьцаа эзэмшигчид

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

Дүгнэлт

Үндэсний Давхар Даатгал ХК (Хувьцаат Компани гэх)-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2025 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын мэдээллийг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББЗОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) -ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад *Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББЗОУСЗ)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байсан бөгөөд НББЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлээр аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад ач холбогдолтой гэж үзсэн асуудлууд юм. Санхүүгийн тайланд гүйцэтгэсэн аудитынхаа хүрээнд дараах асуудлыг аудитын гол асуудлаар авч үзсэн ба энэхүү асуудалд тусдаа дүгнэлт илэрхийлээгүй болно.

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
Ашиг, алдагдал ба дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тэм	2025 он мян.төг	2024 он мян.төг
Даатгалын орлого	5	9,991,705	7,386,567
Даатгалын үйлчилгээний зардал	5	(5,031,547)	(14,423,528)
Давхар даатгалын хураамжийн зардал	5	(3,801,287)	(3,102,413)
Давхар даатгалаас хүлээн авсан нөхөн төлбөр	5	-	8,646,645
Даатгалын үйлчилгээний цэвэр үр дүн		1,158,871	(1,492,729)
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	6	8,628,675	8,530,702
Хөрөнгө оруулалтын орлого		8,628,675	8,530,702
Бусад орлого	7	113,491	202,044
Ерөнхий ба удирдлагын зардал	8	(5,276,829)	(4,556,665)
Бусад үйл ажиллагааны зардал	10	(327,885)	(705,969)
Бусад санхүүгийн зардал	18	(65,148)	(587)
Татварын өмнөх ашиг		4,231,175	1,976,796
Орлогын албан татварын зардал	11	(867,496)	(845,071)
Тайлант жилийн цэвэр ашиг		3,363,679	1,131,725

12-64 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан

	Тэм	2025 оны 12 сарын 31 мян.төг	2024 оны 12 сарын 31 мян.төг
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12	1,332,398	1,630,703
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө	13	62,618,443	57,967,999
Давхар даатгалын гэрээний хөрөнгө	14	1,456,483	1,223,208
Бусад санхүүгийн хөрөнгө	15	2,165	388
Бусад санхүүгийн бус хөрөнгө	16	208,820	142,851
Өмч, барилга, тоног төхөөрөмж	17	159,237	201,788
Хөрөнгө ашиглах эрх	18	388,646	-
Биет бус хөрөнгө	19	1,264	5,054
Нийт хөрөнгө		66,167,456	61,171,991
Өр төлбөр			
Даатгалын гэрээний өр төлбөр	14	13,948,979	11,764,967
Бусад санхүүгийн өр төлбөр	21	34,375	27,992
Түрээсийн өр төлбөр	18	408,897	-
Орлогын татварын өглөг	11	-	410,855
Хойшлогдсон татварын өр төлбөр	20	30,106	20,893
Нийт өр төлбөр		14,422,357	12,224,707
Өмч			
Хувьцаат капитал	22	24,500,000	24,500,000
Алдагдлаас хамгаалах сан	23	19,000,000	19,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	24	4,186,962	4,186,962
Хуримтлагдсан ашиг		4,058,137	1,260,322
Нийт өмч		51,745,099	48,947,284
Нийт өр төлбөр ба өмч		66,167,456	61,171,991

12-64 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.